



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Дүүргийн Орон нутгийн өмчит аж ахуйн
тооцоот үйлдвэрийн газруудын Төлөөлөн
удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хан-Уул дүүргийн Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Б.Цэрэнд)-д даалгасугай.


3. Уг тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 32, 2023 оны 07, 18 дугаар тогтоол, 2024 оны 19 дүгээр тогтоол, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 54 дүгээр тогтоол, 2021 оны 06, 07, 42, 43, 44, 45 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ч.БАТ-ОРГИЛ

Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 11 дугаар сарын 27-ны
өдрийн 11 дугаар тогтоолын нэгдүгээр
хавсралт



**"ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ" ОРОН НУТГИЙН ӨМЧИТ
АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга:

Ц.Эрдэнэбаатар

Дүүргийн менежер

Гишүүд:

Б.Байгалмаа

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгч, 21 дүгээр хорооны
Засаг дарга

Б.Алтантуяа

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгч, 10 дугаар хорооны
Засаг дарга

Ж.Хишигбаяр

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Төлөөлөгч, 16 дугаар хорооны
Засаг дарга

Л.Саруултуяа

Засаг даргын Тамгын газрын Хүнс,
худалдаа, үйлчилгээний хэлтсийн
дарга